

МОНГОЛ, ОРОСЫН ХАМТАРСАН АЛБАН МЭДЭЭ

1. Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Оросын Холбооны Улсын Засгийн газрын дарга В.А.Зубковын урилгаар 2008 оны 4 дүгээр сарын 10-13-нд Москвад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр С.Баяр Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путинд бараалхаж, В.А.Зубковтай хэлэлцээ хийж, Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын дэд дарга В.В.Володинтай уулзав.

2. Итгэлцлийн байдалд болж өнгөрсөн уулзалт, хэлэлцээний явцад Монгол, Оросын харилцааны хөгжил, хэтийн төлвийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, харилцан сонирхсон бүс нутгийн болон олон улсын асуудлаар санал солилцов.

3. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1993 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн гэрээ, 2000 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Улаанбаатарын Тунхаглал болон 2006 оны 12 дугаар сарын 8-ны Москвагийн Тунхаглалд гарын үсэг зурснаас хойшхи хугацаанд эдгээр баримт бичиг амьдралд нийцэн, хоёр орны ард түмний эрх ашигт тохирч байгааг хоёр орны засгийн газрын тэргүүн нар тэмдэглэлээ. Эдгээр үндсэн баримт бичгүүдийг амьдралд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэв.

4. Түүхийн үйл явцад бүрэлдсэн уламжлалт найрамдалт, сайн хөршийн харилцаанд үнэнч гэдгээ батлан бүх талын хамтын ажиллагаа, стратегийн түншлэлийг тууштай хөгжүүлж, хоёр талын хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхийн төлөө ажиллах чин эрмэлзлэлтэй байгаагаа хоёр орны засгийн газрын тэргүүн нар илэрхийлэв.

5. Талууд Монгол, Оросын дээд, өндөр хэмжээний улс төрийн байнгын яриа хэлэлцээний онцгой үүрэг, хоёр талын олон талт хэлхээ холбоог гүнзгийрүүлэх, харилцан айлчлалыг хэрэгжүүлэх, хоёр орны хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын хоорондын гадаад бодлого болон бусад асуудлаар зөвлөлдөх уулзалт хийж байхын ач холбогдлыг тэмдэглэв. Хоёр орны улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах комиссуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэхээр хоёр тал тохиролцов.

6. Талууд Монгол Улс, ОХУ-ын хооронд цэргийн болон цэрэг - техникийн хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байгааг сэтгэл ханамжтайгаар тэмдэглэв.

Монгол, Оросын цэрэг - техникийн хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр боловсруулах хамтарсан ажил дуусах шатандаа орж байна. Цэргийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, зэвсэглэл, цэргийн

техникийг шинэчлэхэд Оросын Холбооны Улс Монгол Улсад тусламж үзүүлж байна. Оросын тал хоёр орны хилийн албаны шугамаар цаашид ч шаардлагатай дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв.

7. С.Баяр, В.А.Зубков нар 2006-2010 оны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцыг хэлэлцэж, түүнийг хэрэгжүүлэх цаашдын алхмуудыг тодорхойлов. Ялангуяа бүс нутаг, хил орчмын хүмүүнлэг, шинжлэх ухаан-техникийн хэлхээ холбоо амжилттай хөгжин байгааг хоёр тал тэмдэглэв.

8. Хоёр тал эдийн засгийн олон салбарт, юуны өмнө түлш, эрчим хүч, геологи, уул, уурхай, тээврийн дэд бүтцийн хөгжил, хөдөө аж ахуй, түүнчлэн хөрөнгө оруулалтын хамтарсан төслүүдийг олон улсын шинэ стандарт болон үндэсний хууль тогтоомжинд нийцүүлэн хэрэгжүүлэх талаар өргөн хүрээнд хамтран ажиллахыг эрмэлзэх болно.

9. Талууд Монгол, Оросын хамтарсан үйлдвэрүүд Монгол Улсын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэв. Үүнтэй холбогдуулан “УБТЗ” хувьцаат нийгэмлэгийн үйл ажиллагааны үр өгөөжийг харилцан тохиролцсон шинэчлэлийн хөтөлбөрийн үндсэн дээр дээшлүүлэх, “УБТЗ”-ын гэрээ-эрхийн үндсийг шинэчлэх ажлыг түргэтгэх арга хэмжээ авахаар тохиролцов.

10. Далайд гарцгүй орны хувьд Монгол Улс өөрийн хөршүүдтэйгээ Дамжин өнгөрөх тээврийн тухай хэлэлцээрийг эцэслэх талаар аль болох ойрын хугацаанд яриа хэлэлцээг сэргээн явуулахыг санал болгов. Оросын тал далайд гарцгүй Монгол Улсын хувьд ийм хэлэлцээр байгуулах нь чухал болохыг ойлгож байгаагаа илэрхийлэв.

11. Хоёр тал Монгол, Оросын бараа эргэлтийн 70 орчим хувь нь ногддог хил орчмын болон бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх явдалд онцгой ач холбогдол өгч байна. Шалган нэвтрүүлэх боомтуудыг тохижуулан, үйл ажиллагааг нь боловсронгуй болгох, жуулчлалыг хөгжүүлэх, юуны өмнө Байгаль, Хөвсгөл нууруудыг түшиглэн хамтарсан жуулчлалын төслүүдийг хэрэгжүүлэхэд тэдгээрийг олон улсын статустай болгох ажлыг үргэлжлүүлэх нь чухал гэж үзэв. Хоёр тал мөн хоёр улсын иргэдийг харилцан зорчиход аль болох тааламжтай нөхцлөөр хангах тухай тохиролцов.

12. Монгол Улс, Оросын Холбооны Улс нь ОХУ-ын их, дээд сургуулиудад суралцах Монголын оюутнуудын тоог нэмэгдүүлэх, мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан сургах, сургалтын хөтөлбөр солилцох, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн зүтгэлтнүүдийн хоорондын харилцаа холбоог хөгжүүлэх замаар хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллана. Талууд хүмүүнлэгийн хамтын ажиллагаа, түүний дотор хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах гэрээ, эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно.

13. Өмнөх тохиролцоог хэрэгжүүлэх үүднээс Улаанбаатар хотын гурван дүүрэг дэх орон сууцны нийт долоон байрыг Оросын Холбооны Улс Монгол Улсад буцалтгүйгээр шилжүүлж байгааг Талууд сэтгэл ханамжтай тэмдэглэв. Талууд Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлуудыг зохицуулах ажлыг үргэлжлүүлж, Улаанбаатар, Дархан хотууд дахь орон сууцны найман байрыг шилжүүлэх ажлыг богино хугацаанд дуусгахаар тохиролцов.

14. Хоёр тал 2009 онд Халх голын ялалтын 70 жилийн ойг хамтран тэмдэглэхээр тохиролцов.

15. Олон улсын тулгамдсан асуудлуудаар хоёр талын байр суурь ижил буюу төстэй байгааг тэмдэглэв.

Олон туйлт дэг журам дэлхийд бүрэлдэж, улс орнууд болон бүс нутгуудын харилцан хамаарал улам нэмэгдэж байгаа нөхцөлд улс орнуудын хоорондын зөрөлдөөн болон хямралт байдлыг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг чанд баримталж, НҮБ-ын Дүрэм болон түүний Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрийн дагуу улс төр - дипломатын арга замаар зохицуулж байх ёстой гэж Талууд цохон тэмдэглэв.

Үүнтэй холбогдуулан хоёр тал олон улсын аюулгүй байдлыг хангах, үй олноор хөнөөх зэвсгийг үл дэлгэрүүлэх болон олон улсын терроризмын аливаа хэлбэр, илрэл, улс үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг болон зэвсэг, мансууруулах бодис, хүн хууль бусаар наймаалах зэрэг дэлхийн хэмжээний зөрчлүүдийг шийдвэрлэх талаар цаашид хамтран ажиллахын төлөө байгаагаа илэрхийлэв.

16. Цөмийн зэвсэггүй статусаа бэхжүүлэх талаар Монгол Улсын хүчин чармайлтыг анхааралдаа аван түүнд Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээний дагуу цөмийн зэвсэггүй оролцогчид олгогдсон баталгаа, түүнчлэн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1995 оны 4 дүгээр сарын 11-ний 984 дүгээр тогтоолоор болон НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн - цөмийн зэвсэгтэй таван улсын 2000 оны 10 дугаар сарын 5-ны Хамтарсан мэдэгдэлд тусгагдсан аюулгүй байдлын баталгааг Оросын Холбооны Улс нотолж байна.

17. Солонгосын хойгийн цөмийн асуудлаархи зургаан талт хэлэлцээг амжилттай үргэлжлүүлэх нь Зүүн Хойд Азид төдийгүй нийт Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалахад чухал болохыг цохон тэмдэглэв. Үүнтэй холбогдуулан Оросын тал, Зүүн Хойд Азийн энх тайван, аюулгүй байдлын талаарх зургаан талт хэлэлцээний ажлын хэсгийн нэг хуралдааныг Улаанбаатарт зохион явуулах Монгол Улсын санаачлагыг дэмжиж байна. Хоёр тал Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлыг хангах талаар, түүнчлэн аюулгүй байдлын асуудлаарх АСЕАН-ы бүсийн

чуулга уулзалт, Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ зэрэг олон талт бусад байгууллагын хүрээнд нягт хамтран ажиллах болно.

18. Талууд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын хүрээнд харилцан үйл ажиллагаа явуулах бөгөөд түүнийг гишүүн орнууд болон ажиглагчдын ашиг сонирхлыг хөндсөн өргөн хүрээний асуудлаархи хамтын ажиллагааны үр нөлөөтэй механизм болгох чиглэлээр ШХАБ-ын үйл ажиллагааг бэхжүүлэх асуудлаар мэдээлэл солилцож, хоёр талын болон олон талын зөвлөлдөх уулзалт зохион байгуулж байхаар тохиролцов.

19. Хоёр тал Ази, Номхон далайн бүс нутагт интеграцчлалын үйл явцыг цаашид хөгжүүлэхийн төлөө байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан бүс нутгийн улс орнуудын эрх ашигт нийцүүлэн эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэх олон талт үр нөлөөтэй механизм болсон Зүүн Өмнөд Азийн улс орнуудын холбоо, “Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа” форумын шугамаар тавьж байгаа хүчин чармайлт чухал болохыг тэмдэглэж байна. Оросын Холбооны Улс Монгол Улсын “Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа” (АПЕК) форумын гишүүн болох эрмэлзлэлд баяр хүргэж байгаа бөгөөд тус форумын гишүүн орны тоог нэмэгдүүлэх тухай АПЕК-ийн хүрээнд зөвшилцөлд хүрсэн тохиолдолд Монгол Улсын хүсэлтийг дэмжих болно.

20. Хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох асуудлуудыг хэлэлцэв. Айлчлалын үеэр дараах баримт бичигт гарын үсэг зурав. Үүнд:

- 1) Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр,
- 2) Мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд болон тэжээл экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх мал эмнэлэг, ариун цэврийн нөхцлийн болон Монгол Улс, Оросын Холбооны Улсын хил орчмын бүс нутагт хэрэгжүүлэх хамтарсан арга хэмжээний тухай Монгол Улсын ХХААЯ, Оросын Холбооны Улсын ХААЯ-ны хоорондын Протокол,
- 3) Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарт 2008-2011 онд хамтран ажиллах тухай хөтөлбөр,
- 4) Ураны хүдэр болон дагалдах ашигт малтмалыг эрж хайх, олборлох, боловсруулах салбарт олон улсын төсөл хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам, Оросын Холбооны Улсын “Росатом” атомын энергийн улсын

корпораци хоорондын хамтарсан арга хэмжээний төлөвлөгөө,

- 5) Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2006 оны 7 дугаар сарын 11-ний өдрийн хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар болон Оросын Холбооны Улсын Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Холбооны аэронавигацийн алба хооронд хамтран ажиллах тухай Ажлын хэлэлцээр,
- 6) Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд Эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай 1999 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн гэрээ болон Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээний нэмэлт Протоколын Батламж жуух бичиг солилцох тухай Протокол,
- 7) Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний төв, Оросын Холбооны Улсын Техникийн зохицуулалт, хэмжил зүйн Агентлаг хоорондын санамж бичиг,
- 8) Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны хооронд 2008 - 2009 онд хамтран ажиллах хөтөлбөр,
- 9) Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Оросын Холбооны Улсын Санкт-Петербургийн Хөдөө аж ахуйн их сургуулийн хооронд хамтран ажиллах Протокол,
- 10) Монголын агаарын тээврийн “МИАТ” компани болон Оросын “Аэрофлот - Российские авиалинии” нээлттэй хувьцаат нийгэмлэг хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,
- 11) Монгол Улсын “Голомт” банк, ОХУ-ын “Оросын хөдөө аж ахуйн банк” нээлттэй хувьцаат нийгэмлэг хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр.

21. Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Москва хотноо халуун дотно хүлээн авсанд талархал илэрхийлж, Оросын Холбооны Улсын Засгийн газрын дарга В.А.Зубковыг тааламжтай цагтаа Монгол Улсад айлчлахыг урив. Урилгыг талархан хүлээн авав.

Москва хот, 2008 оны 4 дүгээр сарын “13 “-ны өдөр